# ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН 2019 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Агуулга

1. Аудитын гэрчилгээ ..... 2
2. Аудитын тайлан ..... 4
2.1. Оршил ..... 4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага ..... 4
2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт ..... 4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин ..... 5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ ..... 5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал ..... 5
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар ..... 6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд ..... 6
2.8.1 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө ..... 6
2.8.3 Авлага ..... 7
2.8.4 Урьдчилгаа ..... 7
2.8.6 Бараа материал ..... 8
2.8.7 Бусад эргэлтийн хөрөнгө ..... 8
2.8.8 Үндсэн хөрөнгө ..... 9
2.8.9 Өр төлбөр ..... 10
2.8.9 Засгийн газрын хувь оролцоо ..... 11
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга ..... 11
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн ..... 12
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал ..... 13
2.12. Шилэн дансны мэдээлэл ..... 13
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт ..... 14
2.14 Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл ..... 14
3. Менежментийн захидал ..... 15
4. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан ..... 17
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл ..... 22

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын Стандарт |
| ХШҮДАГ | Хяналт, шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар |
| ЭМГ | Эрүүл мэндийн газар |
| БОЭТ | Бүсийн оношилгоо, эмчилгээний төв |
| СДЭ | Сум дундын эмнэлэг |
| ЭМЯ | Эрүүл мэндийн яам |
| ЭМДС | Эрүүл мэндийг дэмжих сан |
| АШУҮИС | Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль |
| ЗГНХ | Засгийн газрын нөөц хөрөнгө |

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР
15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2020.04.24 № 1322
танай ____________-ны № ____________-т

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД
Д.САРАНГЭРЭЛ ТАНАА

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

**Зөрчилгүй санал дүгнэлт**

Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн бодитой, шударга илэрхийлсэн байна.

**Санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан. Бидний хийсэн аудит тус санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

\\10.10.10.20\Bichig_Khereg\Yawsan_Bichig\2020\0424SAG20.Docx

001030626

**Үүрэг хариуцлага**

Төсвийн ерөнхийлөн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Д.ЗАНДАНБАТ

\\10.10.10.20\Bichig_Khereg\Yawsan_Bichig\2020\0424SAG20.Docx

## 2. Аудитын тайлан

### 2.1. Оршил

Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Төсвийн ерөнхийлөн захирагч Д.Сарангэрэл танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

### 2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн ерөнхийлөн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 04 дүгээр сарын 05-наас 04 дүгээр сарын 21–ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор Ж.Болормаа хэрэгжүүлэв.

Эрүүл мэндийн сайд 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2020 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн 1а/1582 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитыг Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болгож, батлагдсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хэрэгжүүлэв.

## 2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Эрүүл мэндийн яамны эрхэм зорилго нь шударга өрсөлдөөн, сонголтонд суурилсан, аюулгүй, чанартай эрүүл мэндийн оношилгоо, эмчилгээ, үйлчилгээ авах боломжийг иргэн бүрт олгох олон улсын стандартад нийцсэн нөхцлийг бүрдүүлэх юм. Эрүүл мэндийн сайд Засгийн газрын үйл ажиллагааны эрүүл мэндийн талаарх бодлого, зорилт, хөтөлбөрийг хэрэгжүүлэх үүрэг, хариуцлага хүлээж, салбарын бодлого, төлөвлөлт болон бодлогын хэрэгжилт, түүний үр дүн, төсвийн зарцуулалтын харилцан уялдаа холбоог хангах асуудалд өргөн цар хүрээтэй хандаж, эрүүл мэндийн салбарыг зөв зохистой бодлого, зохицуулалтаар удирдах үүрэг хүлээж байна.

Эрүүл мэндийн сайдын 2019 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд тусгагдсан 4 чиглэлийн 18 ажлаас хорт хавдар шалтгаант нас баралтын түвшин, умайн хүзүүний хорт хавдрын эрт илрүүлгийн хамралтын хувь нь зорилтод түвшинд хүрээгүй байна.

Энэ нь хорт хавдрын өвчлөл жил бүр нэмэгдэх чиг хандлагатай байгаагаас гадна жилд шинээр оношлогдож байгаа тохиолдлын 75-80 хувь нь хожуу үе шатандаа буюу төгс эмчилгээ хийх үе шатаас хэтэрсэн хугацаанд оношлогдож байгаа тул нас баралт нэмэгдсэн, мөн хүн ам олонтой, хөдөлгөөнт хүн ам ихтэй Орхон, Өмнөговь, Улаанбаатар хотод умайн хүзүүний хорт хавдрын эрт илрүүлгийн хамралт 20-30 хувьтай байгаа нь нөлөөлсөн байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

## 2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн нэгтгэсэн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Эрүүл мэндийн салбарын харьяа байгууллагуудын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Тус салбарын үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “бага” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

Тайлант онд ХШҮДАГ нь санхүүгийн 15, төсөл, хөтөлбөрийн 5, хөрөнгө оруулалтын чиглэлээр 10 нийт 30 хяналт шалгалт хийсэн байна. Аудитаар Улсын байцаагчийн 76.1 сая төгрөгийн акт тогтоож бүрэн барагдуулсан бөгөөд 1,543.1 сая төгрөгийн албан шаардлага хүргүүлснээс хэрэгжилт 71.8 хувь, 71 зөвлөмж өгснөөс хэрэгжилт 55 хувьтай байна.

## 2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Эрүүл мэндийн сайдын бэлтгэсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 8 эрсдэлтэй асуудал тодорхойлж нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

### 2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон нүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2018 оны санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “бага” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 797,540.6 сая төгрөгөөс тооцон 15,950.8 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажуулсан.

Гүйцэтгэлийн үе шатанд 2019 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардал 843,184.7 сая төгрөгөөс тооцон материаллаг байдлын түвшинг 16,863.7 сая төгрөгөөр тогтоов.

### 2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

#### 2.8.1 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 26,205.7 сая, эцсийн үлдэгдэл 28,629.8 сая төгргөг болж 2,424.1 сая төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгө /сая төгрөг/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) |
|---|---|---|---|
| Касст байгаа бэлэн мөнгө | 11.9 | 2.6 | -9.3 |
| Банкинд байгаа бэлэн мөнгө | 26,138.9 | 28,587.4 | 2,448.5 |
| Замд яваа мөнгө | 54.9 | 39.8 | -15.1 |
| **Дүн** | **26,205.7** | **28,629.8** | **2,424.1** |
| *Үүнээс, байгууллагын төрлөөр* | | | |
| Төсөвт байгууллага | 23,544.2 | 27,005.2 | 3,461.0 |
| Төсөл/ сан | 2,658.5 | 1,624.2 | -1,034.3 |
| ТӨҮГ болон ОНӨҮГ | 3.0 | 0.4 | -2.6 |
| **Дүн** | **26,205.7** | **28,629.8** | **2,424.1** |

*Эх сурвалж: Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэлд ЭМЯ-ны хөрөнгө оруулалтын барьцаа дансны үлдэгдэл 26,515.0 сая төгрөг, Глобаль сангийн дэмжлэгтэй сүрьеэгийн төслийн 1,151.9 сая төгрөгийг тайлагнасан байна.

*Аудитын илрүүлэлт:*

ЭМЯ, Улсын I төв эмнэлэг, Улсын II төв эмнэлэг, Гэмтэл согог судлалын үндэсний төв, Арьсны өвчин судлалын үндэсний төв, Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв, Эмгэг судлалын үндэсний төв, Халдварт өвчин судлалын үндэсний төв, Геронтологийн үндэсний төв, Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв, Говь-Алтай, Ховд, Дархан-Уул, Баянхонгор, Сэлэнгэ аймгуудын эрүүл мэндийн байгууллагуудын аудитаар мөнгөн хөрөнгө, зардал, худалдан авах ажиллагаатай холбоотой 3,561.5 сая төгрөгийн зөрчил илэрсэн байна. Үүнд:

- Ажлаас халагдсаны тэтгэмж үндэслэлгүй олгосон, шалгуур хангаагүй ажилтнуудад балансын урамшуулал өгсөн;
- Анхан шатны баримтгүй зардал гаргасан;
- Цалин зөрүүтэй тогтоосон, цалингийн урьдчилгаа суутгаагүй;
- Эм тарианы буцаалт хийгээгүй зарцуулсан;
- Төлбөртэй үйлчилгээний орлого бүртгээгүй;
- Хавсран ажилласан нэмэгдэл олгосон;

-Эмнэлгийн хэрэгсэл нийлүүлэх гэрээний дагуу барааг хүлээж аваагүй боловч төлбөр шилжүүлсэн;
- Засварын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулаагүй хувь хүмүүстэй шууд гэрээ байгуулсан;
- Тендерийн баримт бичиг бүрэн бус, гүйцэтгэлийн баталгаа байршуулаагүй;
- Гэрээний дүнгээс илүү худалдан авалт хийсэн;

### 2.8.3 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 5,815.1 сая, эцсийн үлдэгдэл 4,292.5 сая төгрөг болж, 1,522.6 сая төгрөгөөр буурсан байна.

*Хүснэгт №2 Авлага /сая төгрөг/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) |
|---|---|---|---|
| Ажиллагчидтай холбогдсон авлага | 78.9 | 81.9 | 3.0 |
| Төлбөртэй үйлчилгээний авлага | 55.6 | 30.1 | -25.5 |
| Татаас, санхүүжилтийн авлага | 3,098.1 | 476.2 | -2,621.9 |
| Бусад авлага | 2,582.5 | 3,704.3 | 1,121.8 |
| **Дүн** | **5,815.1** | **4,292.5** | **-1,522.6** |
| *Үүнээс, байгууллагын төрлөөр* | | | |
| Төсөвт байгууллага | 4,670.2 | 2,069.4 | -2,600.8 |
| Төсөл/ сан | 1,119.9 | 2,221.3 | 1,101.4 |
| ТӨҮГ болон ОНӨҮГ | 25.0 | 1.8 | -23.2 |
| **Дүн** | **5,815.1** | **4,292.5** | **-1,522.6** |

*Эх сурвалж: Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Авлага дансны үлдэгдэлд ЭМЯ-ны эмнэлгийн хэрэгсэл худалдан авах гэрээний дагуу шилжүүлсэн төлбөр болон хувь хүмүүсээс авах авлага 1,028.2 сая төгрөг, Глобаль сангийн дэмжлэгтэй сүрьеэгийн төслийн гадаад ханган нийлүүлэгч байгууллагаас авах эм, эмнэлгийн хэрэгслийн авлага 2,190.2 сая төгрөг тайлагнасан байна.

*Аудитын илрүүлэлт:*

Улсын III төв эмнэлэг, Баян-Өлгий, Дорнод, Ховд, Өмнөговь, Хэнтий, Сэлэнгэ, Дорноговь, Завхан, Баянхонгор, Говь-Алтай аймгуудын болон Нийслэлийн эрүүл мэндийн байгууллагуудын аудитаар авлагатай холбоотой 282.7 сая төгрөгийн зөрчил илэрсэн. Үүнд:

- Өндөр өртөгтэй тусламж үйлчилгээний авлага үүссэн;
- Гэрээ байгуулаагүй байхад мөнгийг шилжүүлж авлагаар тусгаагүй;
- Тайлант онд авлага нэмж үүссэн;
-Авлага, өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй, өндөр насжилттай авлага бууруулж ажиллаагүй;
- Авлагын эзэн холбогдогчийн талаар шүүхийн байгууллагад хүсэлт гаргах ажил зохион байгуулаагүй;

### 2.8.4 Урьдчилгаа

Урьдчилгаа дансны эхний үлдэгдэл 42,273.2 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 98.9 сая төгрөг болж, 42,174.4 сая төгрөгөөр буурсан байна.

*Хүснэгт №3 Урьдчилгаа /сая төгрөг/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) |
|---|---|---|---|
| Урьдчилж гарсан зардал | 42,273.2 | 98.9 | -42,174.4 |
| **Дүн** | **42,273.2** | **98.9** | **-42,174.4** |
| *Үүнээс, байгууллагын төрлөөр* | | | |
| Төсөвт байгууллага | 42,174,6 | 98.9 | -42,075.7 |
| Төсөл/ сан | 98.6 | - | -98.6 |
| **Дүн** | **42,273.2** | **98.9** | **-42,174.4** |

*Эх сурвалж: Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Урьдчилгаа данс буурсан нь зээл, тусламжаар хэрэгжиж байгаа төслүүд Сангийн сайдын төсвийн багцад шилжсэнтэй холбоотой бөгөөд үлдэгдэлд Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв, Нийслэлийн ЭМГ, ЭМДС-гийн урьдчилж төлсөн зардал бүртгэлтэй байна.

*Аудитын илрүүлэлт:*

ЭМДС-гийн аудитаар урьдчилгаа данстай холбоотой 24.3 сая төгрөгийн он дамжсан, эзэн холбогдогч тодорхойгүй урьдчилж гарсан зардал бүртгэлтэй байна.

### 2.8.6 Бараа материал

Бараа материалын эхний үлдэгдэл 53,609.0 сая, эцсийн үлдэгдэл 64,335.2 сая төгрөг болж, 10,726.2 сая төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт №4 Бараа материал /сая төгрөг/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) |
|---|---|---|---|
| Түүхий эд материал | 32,016.6 | 36,555.3 | 4,538.7 |
| Дуусаагүй үйлдвэрлэл | 184.3 | 69.5 | -114.8 |
| Бэлэн бүтээгдэхүүн | 4,755.4 | 5,330.7 | 575.3 |
| Хангамжийн материал | 16,493.4 | 22,209.8 | 5,716.4 |
| Мал амьтад | 159.4 | 169.9 | 10.6 |
| **Дүн** | **53,609.0** | **64,335.2** | **10,726.2** |
| *Үүнээс, байгууллагын төрлөөр* | | | |
| Төсөвт байгууллага | 53,413.7 | 60,536.9 | 7,123.2 |
| Төсөл/ сан | 171.8 | 3,776.0 | 6,604.2 |
| ТӨҮГ болон ОНӨҮГ | 23.5 | 22.3 | -1.2 |
| **Дүн** | **53,609.0** | **64,335.2** | **10,726.2** |

*Эх сурвалж: Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Тайлант онд төсөвт байгууллагуудын бараа материал 7,123.2 сая төгрөгөөр, Глобаль сангийн дэмжлэгтэй ДОХ, сүрьеэгийн төслийн бараа материал 3,604.2 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

*Аудитын илрүүлэлт:*

Халдварт өвчин судлалын үндэсний төв, Говь-Алтай, Говьсүмбэр, Дорнод, Өвөрхангай, Сэлэнгэ, Дорноговь, Төв аймгуудын болон Нийслэлийн эрүүл мэндийн байгууллагуудын аудитаар бараа материалтай холбоотой нийт 1,414.8 сая төгрөгийн зөрчил илэрсэн байна. Үүнд:

- Бараа материалын дансанд үндсэн хөрөнгө бүртгэсэн;
- Бараа материалын зарлагын баримтын гарын үсэг дутуу;
- Худалдан авсан бараа материалыг шууд зарлагадсан;
- Хөрөнгө, бараа материал шууд худалдан авсан;
- Бараа материалын худалдан авалтын анхан шатны баримтад е-баримт хавсаргаагүй;
- Нийт худалдан авалтын 7.0 хувийг татварын нэгдсэн цахим хуудас дахь е-баримтад бүртгээгүй;
- Албан ажлын суудлын автомашин хэрэглэх эрхгүй байхад тодорхой ажлын гүйцэтгэлгүйгээр шатахуун зарцуулсан;
- Анхан шатны тусламжийн эмийн сангийн /2200ш/ 49.5 сая төгрөгийн худалдан авалтыг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулаагүй, эмийн сангийн /408 ш/ 9.2 сая төгрөгийн үлдэгдлийг санхүүгийн тайлан, тодруулгад зардлаар илэрхийлсэн;

### 2.8.7 Бусад эргэлтийн хөрөнгө

Бусад эргэлтийн хөрөнгө дасны үлдэгдэл 301,381.6 сая төгрөг байна.

*Хүснэгт №5 Бусад эргэлтийн хөрөнгө /сая төгрөг/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) |
|---|---|---|---|
| Бусад эргэлтийн хөрөнгө | - | 301,381.6 | 301,381.6 |

| | | | |
|---|---|---|---|
| **Дүн** | - | **301,381.6** | **301,381.6** |
| *Үүнээс, байгууллагын төрлөөр* | | | |
| Төсөвт байгууллага | - | 301,381.6 | 301,381.6 |
| **Дүн** | **-** | **301,381.6** | **301,381.6** |

*Эх сурвалж: Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Төсвийн хөрөнгө оруулалтаар барьж байгуулж байгаа дуусаагүй барилга байгууламжийг өмнөх онд үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй байсныг Сангийн Сайдын 2016 оны 415 дугаар тушаалаар баталсан журмын дагуу бусад эргэлтийн хөрөнгөнд шилжүүлж бүртгэсэн байна.

### 2.8.8 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 1,028,176.9 сая, эцсийн үлдэгдэл 825,108.4 сая төгрөг болж, 203,068.5 сая төгрөгөөр буурсан байна.

*Хүснэгт №6 Үндсэн хөрөнгө /сая төгрөг/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) |
|---|---|---|---|
| **Биет хөрөнгө** | **982,733.1** | **775,941.4** | **-206,791.8** |
| Барилга, байгууламж, орон сууц | 545,364.8 | 580,926.4 | 35,561.6 |
| Хуримтлагдсан элэгдэл | -19,729.2 | -38,583.7 | -18,854.5 |
| Авто-тээврийн хэрэгсэл | 28,018.5 | 32,357.5 | 4,339.0 |
| Хуримтлагдсан элэгдэл | -19,414.3 | -21,040.2 | -1,625.9 |
| Машин тоног төхөөрөмж | 377,054.4 | 465,968.5 | 88,914.1 |
| Хуримтлагдсан элэгдэл | -226,050.1 | -266,432.9 | -40,382.8 |
| Тавилга, аж ахуйн эд хогшил | 29,873.2 | 35,092.2 | 5,219.0 |
| Хуримтлагдсан элэгдэл | -17,975.3 | -20,698.4 | -2,723.1 |
| Зам гүүрийн барилга, байгууламж | 346.4 | 347.1 | 0.7 |
| Хуримтлагдсан элэгдэл | -124.4 | -155.5 | -31.1 |
| Түүх соёл, музейн дурсгалт зүйлс | 6.0 | 6.0 | - |
| Бусад үндсэн хөрөнгө | 244,901.2 | 5,693.3 | -239,207.9 |
| Хуримтлагдсан элэгдэл | -1,946.3 | -2,477.6 | 531.3 |
| Дуусаагүй барилга | 42,199.3 | 4,725.9 | -37,473.4 |
| Ном | 208.8 | 212.7 | 3.9 |
| **Биет бус хөрөнгө** | **45,443.8** | **49,167.0** | **3,723.3** |
| Програм хангамж | 2,208.9 | 3,022.9 | 814.0 |
| Хуримтлагдсан элэгдэл | -1,727.4 | -1,689.1 | 38.3 |
| Бусад биет бус хөрөнгө | 45,180.3 | 48,127.4 | 2,947.1 |
| Хуримтлагдсан элэгдэл | -218.1 | -294.3 | -76.2 |
| **Дүн** | **1,028,176.9** | **825,108.4** | **-203,068.5** |
| *Үүнээс, байгууллагын төрлөөр* | | | |
| Төсөвт байгууллага | 1,027,846.0 | 824,812.5 | -203,033.6 |
| Төсөл/ сан | 155.1 | 134.5 | -20.5 |
| ТӨҮГ болон ОНӨҮГ | 175.8 | 161.4 | -14.4 |
| **Дүн** | **1,028,176.9** | **825,108.4** | **-203,068.5** |

*Эх сурвалж: Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Тайлант онд төслийн нэгжүүд сангийн сайдын төсвийн багцад шилжсэн, Эрүүл мэндийн салбарын хөрөнгө оруулалт, их засварын хөрөнгийг бусад эргэлтийн хөрөнгөд шилжүүлж бүртгэсэн зэргээс шалтгаалж үндсэн хөрөнгийн данс буурсан байна.

*Аудитын илрүүлэлт:*

Улсын III төв эмнэлэг, Зоонозын өвчин судлалын үндэсний төв, Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв, Говьсүмбэр, Баян-Өлгий, Булган, Өмнөговь, Өвөрхангай, Говь-Алтай аймаг, Нийслэлийн эрүүл мэндийн байгууллагуудын аудитаар үндсэн хөрөнгөтэй холбоотой нийт 914.8 сая төгрөгийн зөрчил илэрсэн. Үүнд:

- Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардлаас хөрөнгө бэлтгэсэн;
- ТӨБЗГ-ын шийдвэргүй хөрөнгө бэлтгэсэн;

- Гэрээнд заагдсан хугацаанд засварын ажил хийгдээгүй;
- Элэгдлээрээ өртгөө нөхсөн ашиглах боломжгүй хөрөнгө бүртгэлтэй;
- Тендерийн гүйцэтгэлийн баталгаа гаргуулаагүй.
- Мэдээлэл технологийн зардлаас хөрөнгө бэлтгэсэн;
- Ашиглах боломжгүй болсон санхүүгийн "Plastic" программыг акталж данснаас хасаагүй;
- Эрүүл мэндийн даатгалын сангийн хөрөнгөнөөс үндсэн хөрөнгө бэлтгэсэн;
- Үндсэн хөрөнгийн дансанд 14.0 сая төгрөгийн тусгай зориулалтын бараа материалыг бүртгэсэн;
- Хөрөнгийг тулган баталгаажуулахад биетээр байгууллагад байхгүй 8.8 сая төгрөгийн хөрөнгө /вакцины хөргөгч, тог баригч/-ийг санхүүгийн тайланд толилуулсан, тухайн байгууллагад данс бүртгэлтэй нийт 6.7 сая төгрөгийн хөрөнгө /хүчилтөрөгч өтгөрүүлэгч, шарах шүүгээ, өвчтөний хяналтын монитор/-ийг эрх бүхий байгууллагын шийдвэргүй шилжүүлсэн;
- Үндсэн хөрөнгийн элэгдэл байгуулахдаа 3 нэр төрлийн 31.3 сая төгрөгийн хөрөнгийн ашиглалтын хугацааг программд оруулаагүйгээс элэгдэл тооцогдоогүй;
- Хөрөнгийн тооллогын дүн нягтлан бодох бүртгэлийн дүнгээс 57.0 сая төгрөгөөр зөрүүтэй;

### 2.8.9 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 9,114.1 сая, эцсийн үлдэгдэл 30,665.3 сая төгрөг болж, 21,551.2 сая төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт №7 Өр төлбөр /сая төгрөг/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) |
|---|---|---|---|
| Ажилчидтай холбогдсон өглөг | 203.7 | 244.1 | 40.4 |
| Бараа үйлчилгээний зардлын өглөг | 55.7 | 734.4 | 678.7 |
| Хөрөнгө бэлтгэхтэй холбоотой өглөг | 1,896.8 | - | -1,896.8 |
| Бусад өглөг | 5,805.6 | 28,061.1 | 22,255.5 |
| Урьдчилж орсон орлого | 1,152.3 | 1,625.7 | 473.4 |
| **Дүн** | **9,114.1** | **30,665.3** | **21,551.2** |
| *Үүнээс, байгууллагын төрлөөр* | | | |
| Төсөвт байгууллага | 8,759.2 | 28,883.6 | 20,124.4 |
| Төсөл/ сан | 253.9 | 1,704.1 | 1,450.2 |
| ТӨҮГ болон ОНӨҮГ | 100.9 | 77.6 | -23.3 |
| **Дүн** | **9,114.1** | **30,665.3** | **21,551.2** |

*Эх сурвалж: Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Богино хугацаат өр төлбөрийн үлдэгдэлд ЭМЯ-ны хөрөнгө оруулалтын барьцаа хөрөнгийн дансанд шилжүүлсэн гүйцэтгэгчид олгох 24,718.1 сая төгрөг, Нийслэлийн ЭМГ-ын тайлан дахь эмийн өр 1,433.6 сая төгрөг тайлагнасан байна.

*Аудитын илрүүлэлт:*

Арьсны өвчин судлалын үндэсний төв, Грентологийн үндэсний төв, Баян-Өлгий, Ховд, Өвөрхангай, Сүхбаатар, Дорноговь, Булган, Өмнөговь, Говь-Алтай аймаг, Нийслэлийн эрүүл мэндийн байгууллагуудын аудитаар өр төлбөртэй холбоотой нийт 811.9 сая төгрөгийн зөрчил илэрсэн. Үүнд:

- Тайлант онд ХХОАТ-ын өр үүссэн;
- Оны эцэст эм, халаалт, шатахуун, цалингийн татварын тооцоогоор өглөг үүсгэсэн;
- Нийт 437.0 сая төгрөгийн өглөг үүсгэсэн;
- Татварын хэлтэс ХХОАТ 0.66 сая төгрөгийг дутуу төлсөн;
- Ажиллагсдад тэтгэмж олгохдоо 0.1 сая төгрөгийн ХХОАТ суутгасан;
- Татварын тайланг 0.52 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан;

### 2.8.9 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 1,146,965.8 сая, эцсийн үлдэгдэл 1,193,180.9 сая төгрөг болж, 46,215.1 сая төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт №8 Засгийн газрын хувь оролцоо /сая төгрөг/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) |
|---|---|---|---|
| Засгийн газрын оруулсан капитал | 368,724.5 | 368,888.3 | 163.8 |
| Өмч /төрийн/ /ТӨҮГ/ | 301.8 | 301.8 | - |
| Хуримтлагдсан үр дүн | 429,990.6 | 473,926.0 | 43,935.4 |
| Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 347,948.9 | 350,064.8 | 2,115.9 |
| **Дүн** | **1,146,965.8** | **1,193,180.9** | **46,215.1** |

*Эх сурвалж: Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Цэвэр хөрөнгө өмчийн дүн өссөн нь хуримтлагдсан үр дүн данс 43,935.5 сая төгрөгөөр нэмэгдсэнтэй холбоотой байна. Мөн хөрөнгө оруулалтын дууссан барилга байгууламжийг шилжүүлсэн болон харьяа байгууллагуудад хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү гарсантай холбоотой 159,301.2 сая төгрөгийг нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт дансанд бүртгэсэн байна.

### 2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсөв захирагч нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлэх 4 хөтөлбөрт зориулан 839,948.8 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 581,791.1 сая төгрөгийг бараа, үйлчилгээний зардалд, 153,919.8 сая төгрөгийг татаас, урсгал шилжүүлэгт, 104,237.9 сая төгрөгийг хөрөнгийн зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 584,802.9 сая төгрөгийг улсын төсвөөс, 228,170.4 сая төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сангаас, 26,975.5 сая төгрөгийг үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ. Гүйцэтгэлээр 573,519.5 сая төгрөгийг улсын төсвөөс, 221,061.4 сая төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сангаас, 28,440.9 сая төгрөгийг үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 823,033.6 сая төгрөг буюу 97.9 хувьтай байгаа нь урсгал зардал 8,902.8 сая төгрөг, хөрөнгийн зардал 8,012.5 сая төгрөгийг зарцуулаагүйтэй холбоотой байна.

Улсын эмнэлгүүдийн үйл ажиллагаа өргөжиж, нарийн мэргэжлийн тоног төхөөрөмж, оношилгоо эмчилгээ нэмэгдэж байгаатай холбоотой эмч, сувилагчдын тоо өссөн боловч төсвийн төлөвлөгөөнд тусгаж батлахгүй байгаагаас орон тоо хэтрэлттэй гарч байна.

**Нэмэлт төсөв:** Нэмэлт санхүүжилтийн 177 дансаар 27,532.2 сая төгрөгийн санхүүжилтийг дараах байгууллагуудаас авч холбогдох төсөл, арга хэмжээнд зарцуулсан байна. Үүнд:

- Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж 7,522.1 сая,
- ЗГНХ, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 3,388.1 сая,
- Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 3,923.1 сая
- Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого буюу давсан орлого 13,667.7 сая төгрөг байна.

Үүнээс улсын төсөвт 715.5 сая төгрөг төвлөрүүлснээс 463.2 сая төгрөгийг өглөгт тооцож, 252.3 сая төгрөгийг улсын төсвийн орлогод төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

### 2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргалаа.

Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд 190 тайлан нэгтгэснээс төсвийн байгууллагын 147, Засгийн газрын тусгай сангийн 1, төсөл, хөтөлбөрийн 17, төрийн өмчит үйлдвэрийн газрын 2, хөрөнгө оруулалтын дансны 1, тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын 22 тайлан нэгтгэгдсэн байна.

Үүнээс, 153 тайлан аудитад хамрагдсанаас Зөрчилгүй 126, Хязгаарлалттай 11, Сөрөг 1, Дүгнэлт өгөхөөс татгалзсан 1, итгэл үзүүлсэн 12, түүвэрт хамрагдсан 2 тайлан байна.

Говь-Алтай аймгийн Баян-Уул сумын сум дундын эмнэлгийн 2019 оны санхүүгийн тайланд ажиллагсдын цалин, цалингийн нэмэгдлийг зөрүүтэй тооцсон, авлага, өглөгийг зөв тооцоогүй улмаас бэлтгэн нийлүүлэгч, татвар, нийгмийн даатгалын байгууллагад илүү мөнгө шилжүүлсэн, хөрөнгийн элэгдлийг үнэн зөв тооцоолоогүй, худалдан авах үйл ажиллагаа зохион байгуулаагүй зэрэг 138.9 сая төгрөгийн зөрчил илэрсэн тул Сөрөг дүгнэлт өгсөн байна.

Мөн Өмнөговь аймгийн Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн 2019 оны санхүүгийн тайланд бараа материалын үлдэгдэл зөрүүтэй, үнэ төлбөргүй хүлээн авсан бараа материалын орлого дутуу, цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал дутуу тайлагнасан, авлага хааж бүртгээгүй, өмнөх оны зөвлөмж хэрэгжүүлээгүй зэрэг нийт 2,944.4 сая төгрөгийн зөрчил илэрсэн тул Дүгнэлт өгөхөөс татгалзсан байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2-т “дараах тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ”, 28.2.1-д “аудитад хамрагдсан байгууллагын санхүүгийн тайланд төрийн аудитын байгууллагаас санал, дүгнэлт өгөх боломжгүй тохиолдолд” гэсэн заалтын дагуу арга хэмжээ авах саналыг албан шаардлагаар хүргүүлсэн.

Төсвийн шууд захирагчдын 2019 оны санхүүгийн тайлангийн аудитаар “Хязгаарлалттай” дүгнэлт авсан дараах байгууллагууд байна. Үүнд,

- Геронтологийн үндэсний төв
- Халдварт өвчин судлалын үндэсний төв
- Уламжлалт анагаах ухааны элэг судлалын клиник төв
- Баян-Өлгий аймгийн Дэлүүн Сум дундын эмнэлэг
- Баянхонгор аймгийн Эрүүл мэндийн газар
- Говь-Алтай аймгийн Нэгдсэн эмнэлэг
- Говь-Алтай аймгийн Бигэр Сум дундын эмнэлэг
- Дорноговь аймгийн Нэгдсэн эмнэлэг
- Завхан аймгийн Шилүүстэй Сум дундын эмнэлэг
- Сүхбаатар аймгийн Эрүүл мэндийн газар
- Ховд аймгийн Эрүүл мэндийн газар байна.

Эрүүл мэндийн сайдын хөрөнгө оруулалтын тайлан болон АШУҮИС-ын эмнэлгийн 2019 оны санхүүгийн тайлан аудитын түүвэрт хамрагдсан.

АШУҮИС-ийн эмнэлгийн барилга байгууламж болон тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг Япон Улсын Олон улсын хамтын ажиллагааны байгууллагын 189,004.7 сая төгрөгийн буцалтгүй тусламжийн хөрөнгөөр санхүүжүүлсэн байна. Япон Улсын Засгийн газар 2019 оны 6 дугаар

сарын 16-ны өдөр эмнэлгийн үйл ажиллагааг нээж Монгол Улсад хүлээлгэн өгсөн боловч 2020 оны төсвийн төсөлд үйл ажиллагааны зардлын төсөв 17,922.6 сая төгрөгөөр санал өгснийг 4,500.0 сая төгрөгөөр баталснаас үйл ажиллагаа доголдож одоог болтол жигдрээгүй байна.

Улсын II дугаар төв эмнэлгийн харьяа Үндэсний оношилгоо, эмчилгээний төвийн хөрөнгө оруулалтын 117,014.8 сая төгрөгийг Эрүүл мэндийн яамны хөрөнгө оруулалтын тайланд тайлагнасан байна.

Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын хүрээний харьяа байгууллагуудын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар 6,304.2 сая төгрөгийн 19 алдааг аудитын явцад залруулж, залруулагдаагүй нийт 7,143.2 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 197.5 сая төгрөгийн зөрчилд 68 төлбөрийн акт тогтоож, 3,613.2 сая төгрөгийн зөрчлийг арилгах 104 албан шаардлага өгч, 3,332.5 сая төгрөгийн алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх 270 зөвлөмжийг хүргүүлсэн байна.

Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар 67,068.7 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 55,599.6 сая төгрөгийн алдааг залруулж 6,827.1 сая төгрөгийн алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх 4 зөвлөмжийг хүргүүлсэн.

*Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн залруулга*

1. Нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлангийн тайлант үеийн үр дүн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн үйл ажиллагааны нийт үр дүнгээс 88.8 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх” гэж заасантай нийцэхгүй байна.

   Шийдвэрлэсэн нь: Аудитын явцад залруулсан.

2. Хөрөнгө оруулалтын тайланд 228,445.6 сая төгрөгийн дуусаагүй барилга байгууламжийг бусад үндсэн хөрөнгөөр бүртгэсэн нь Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналын журам”-ын 6.1-д “... барилга байгууламжийг барьж дуусах хүртэл, худалдан авсан тоног төхөөрөмжийг ашиглалтанд хүлээн авсан эцсийн гүйцэтгэлийн дүнгээр захиалагч байгууллага эргэлтийн бусад хөрөнгөөр бүртгэн санхүүгийн тайландаа тусгана” гэж заасантай нийцэхгүй байна.

   Хөрөнгө оруулалтын санхүүгийн тайланд эрх шилжүүлж барьж дууссан барилга байгууламжийн санхүүжилт 55,510.8 сая төгрөг бүртгэлтэй байна.

   Шийдвэрлэсэн нь: Аудитын явцад залруулсан.

**2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал**

Дэлхийн улс орнуудад тархаад байгаа шинэ короновируст халдвар (COVID-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны санхүүжилт, хандив, тусламжийн зарцуулалт, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний бэлэн байдлыг хангахад нэн шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл, багаж, тоног төхөөрөмжийн худалдан авалтыг дараагийн аудитаар авч үзэх шаардлагатай.

**2.12. Шилэн дансны мэдээлэл**

Эрүүл мэндийн сайд Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд төсөв/гүйцэтгэл, хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалт, бусад гэсэн цэсүүдэд заасан мэдээллээс улирлын дүнгээр 2 мэдээлэл хугацаа хоцроож мэдээлсэн, хагас, бүтэн жилийн санхүүгийн тайланг мэдээлээгүй байна.

Тус байгууллагын Шилэн дансны тухай хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

**2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар өгсөн 6 албан шаардлага, 3 зөвлөмжийн биелэлт 90.8 хувь байна. Үүнд, БЗД-ийн Хонхор тосгоны эрүүл мэндийн төвийн барилгыг Улсын комисст хүлээлгэж өгөх албан шаардлага хэрэгжээгүй байна.

**2.14 Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны жилийн эцсийн нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлснийг Аудитын гэрчилгээнд дурдав.

## 3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд Менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн нэгтгэсэн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй, анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

### 3.1 Хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэлийн талаар

3.1.1 Илрүүлэлт
Эрүүл мэндийн салбарт төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд барилга байгууламж, их засвар, тоног төхөөрөмжийн 104,237.9 сая төгрөгийн 75 ажил тусгагдсанаас 6,500.0 сая төгрөгийн 4 ажил хийгдээгүй, гүйцэтгэл 96,225.4 сая төгрөг буюу 92.3 хувьтай байна.

3.1.2 Эрсдэл:
Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөлт бодитой бус байх

3.1.3 Өгсөн зөвлөмж:
Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4-д “Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана” гэж заасныг хэрэгжүүлж ажиллах

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:
Асуудлын бүртгэлээр төсвийн захирагчид танилцуулсан.

### 3.2 Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй номын талаар

3.2.1 Илрүүлэлт
Үндсэн хөрөнгийн стандартын шаардлагад нийцэхгүй нийт 212.7 сая төгрөгийн ном 36 байгууллагын үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй байгаа нь УСНББОУС 17 Үндсэн хөрөнгө-ийн 43-д "Хөрөнгө гэж хүлээн зөвшөөрсний дараа үед үндсэн хөрөнгийн тухайн зүйлийг түүний өртгөөс хуримтлагдсан элэгдэл ба хуримтлагдсан үнэ цэнийн бууралтын аливаа гарзыг хассан дүнгээр дансанд бүртгэнэ" гэж заасантай нийцэхгүй байна.

3.2.2 Эрсдэл:
Санхүүгийн тайлан үнэн зөв илэрхийлэгдэхгүй байх

3.2.3 Өгсөн зөвлөмж:
Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-д “Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт-ыг дагаж мөрдөнө“ гэж заасныг хэрэгжүүлж ажиллах

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:
Асуудлын бүртгэлээр төсвийн захирагчид танилцуулсан.

**3.3 Шагнал урамшууллын зардлын талаар**

3.3.1 Илрүүлэлт
Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/303 дугаар тушаалаар аудитын зөрчилгүй дүгнэлт авсан, ажлын үр дүнгээр хангалттай үнэлэгдсэн байгууллагуудын дарга, санхүүгийн ажилтнуудыг батлагдсан төсөвтөө багтаан урамшуулал олгохыг зөвшөөрсний дагуу холбогдох эмнэлгүүд нийт 115.2 сая төгрөг зарцуулж 3 сар хүртэл цалинтай тэнцэх хэмжээний урамшууллыг байгууллагын дарга, санхүүгийн ажилтнууд, хүний нөөц, дотоод аудит, бусад мэргэжилтнүүдэд олгосноос “Хязгаарлалттай” дүгнэлт авсан байгууллагын албан тушаалтнууд байна.

3.3.2 Эрсдэл:
Ажлын үр дүнгийн үнэлгээ бодитой бус байх, төсвийн төлөвлөгөөнд батлагдаагүй зардал гарах

3.3.3 Өгсөн зөвлөмж:
Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2-д “Нягтлан бодох бүртгэлийн ажилд үр бүтээл гарган ажилласан нягтлан бодох бүртгэлийн ажилтныг шагнаж урамшуулж болно” гэж заасны дагуу нягтлан бодох бүртгэлийн ажилтнуудын ажлыг бодитой үнэлэх, урамшууллын хэмжээг жигд тогтоох

3.3.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:
Асуудлын бүртгэлээр төсвийн захирагчид танилцуулсан.

**3.4 Харьяа байгууллагуудын аудитын талаар**

3.4.1 Илрүүлэлт
Харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар нийт 4,641.1 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрч, Хязгаарлалттай, Сөрөг, Дүгнэлт өгөхөөс татгалзсан дүгнэлттэй 13 байгууллага байна.

3.4.2 Эрсдэл:
Санхүү, бүртгэлийн үйл ажиллагаа доголдох, сахилга хариуцлага сулрах

3.4.3 Өгсөн зөвлөмж:
Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3-д “Төсвийн ерөнхийлөн захирагч өөрийн эрхлэх асуудлын төсвийн орлого, зарлагын зүй зохистой, үр ашигтай байдал, үр дүнгийн гүйцэтгэлийг хангаж, өөрт хамаарах төсвийн гүйцэтгэлийн биелэлтийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засгийн газар, Улсын Их Хурлын өмнө бүрэн хариуцна” гэж заасныг хэрэгжүүлж ажиллах, холбогдох албан тушаалтнуудад хариуцлага тооцох

3.4.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:
Асуудлын бүртгэлээр төсвийн захирагчид танилцуулсан.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 09 дүгээр сарын 15-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 4. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан

### 4.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

| Код: | Тайлангийн үзүүлэлт | 2018 оны 12-р сарын 31 | 2019 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 127,903,022.2 | 398,737,987.4 |
| 31 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | 26,205,701.6 | 28,629,789.6 |
| 33 | АВЛАГА | 5,815,056.9 | 4,292,502.5 |
| 34 | УРЬДЧИЛГАА | 42,273,232.8 | 98,854.1 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 53,609,030.9 | 64,335,198.4 |
| 360 | БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ | 0.0 | 301,381,642.9 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 1,028,176,895.6 | 825,108,357.5 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 1,028,176,895.6 | 825,108,357.5 |
| 39200 | Биет хөрөнгө | 982,733,134.5 | 775,941,325.1 |
| 39300 | Биет бус хөрөнгө | 45,443,761.1 | 49,167,032.5 |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | 1,156,079,917.8 | 1,223,846,345.0 |
| 4 | НИЙТ ӨР ТӨЛБӨР | 9,114,114.2 | 30,665,348.5 |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 9,114,114.2 | 30,665,348.5 |
| 41300 | Өглөг | 7,961,829.1 | 29,039,615.7 |
| 41400 | Урьдчилж орсон орлого | 1,152,285.2 | 1,625,732.8 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 1,146,965,803.6 | 1,193,180,996.4 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 1,146,965,803.6 | 1,193,180,996.4 |
| 51100 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 368,724,505.0 | 368,888,337.8 |
| 51101 | Өмч /төрийн/ /ТӨҮГ/ | 301,823.1 | 301,823.1 |
| 51200 | Хуримтлагдсан үр дүн | 429,990,521.3 | 473,926,018.8 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 347,948,954.2 | 350,064,816.7 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | 1,156,079,917.8 | 1,223,846,345.0 |

### 4.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

| Код: | Тайлангийн үзүүлэлт | 2018 оны 12-р сарын 31 | 2019 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 938,074,321.8 | 1,046,236,568.3 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 269,332,954.1 | 251,548,031.6 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 167,384,400.4 | 233,759,905.4 |
| 122 | Тусламжийн орлого | 101,948,553.7 | 17,788,126.1 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 668,741,367.7 | 794,688,536.8 |
| II | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 779,858,251.2 | 839,256,954.1 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 725,926,820.7 | 839,256,954.1 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 581,066,686.9 | 685,283,039.5 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 230,943,783.6 | 288,028,160.8 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 27,879,069.2 | 36,300,494.8 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 28,369,642.8 | 30,599,115.3 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 13,497,207.1 | 16,256,618.0 |
| 2105 | Нормативт зардал | 167,568,784.0 | 186,465,614.7 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 6,938,869.5 | 9,795,297.3 |

| | | | |
|---|---|---|---|
| 2107 | Томилолт, зочны зардал | 2,154,828.8 | 2,852,646.4 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 9,496,665.9 | 12,871,200.4 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 94,217,836.1 | 102,113,891.9 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 144,860,133.8 | 153,973,914.6 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 53,931,430.5 | 0.0 |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II) | 158,216,070.7 | 206,979,614.3 |
| IV | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН | 419,063.9 | 184,887.1 |
| V | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | 17,971,674.3 | 3,927,775.7 |
| VI | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V) | 140,663,460.2 | 203,236,725.6 |

### 4.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

| Код: | Тайлангийн үзүүлэлт | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн | Цөөнхийн хувь оролцоо | Нийт цэвэр хөрөнгө/өмч |
|---|---|---|---|---|
| 1 | 2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 693,807,475.7 | 0.0 | 693,807,475.7 |
| 2 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 58,086,983.2 | 0.0 | 58,086,983.2 |
| 3 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 751,894,458.9 | 0.0 | 751,894,458.9 |
| 4 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт | 199,167,258.6 | 0.0 | 199,167,258.6 |
| 5 | Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт | 55,240,625.8 | 0.0 | 55,240,625.8 |
| 9 | Тайлант үеийн үр дүн | 140,663,460.2 | 0.0 | 140,663,460.2 |
| 10 | 2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 1,146,965,803.6 | 0.0 | 1,146,965,803.6 |
| 12 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | -159,301,228.1 | 0.0 | -159,301,228.1 |
| 13 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 987,664,575.4 | 0.0 | 987,664,575.4 |
| 14 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт | 2,115,862.5 | 0.0 | 2,115,862.5 |
| 15 | Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт | 163,832.9 | 0.0 | 163,832.9 |
| 19 | Тайлант үеийн үр дүн | 203,236,725.6 | 0.0 | 203,236,725.6 |
| 20 | 2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 1,193,180,996.4 | 0.0 | 1,193,180,996.4 |

### 4.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

| Код: | Тайлангийн үзүүлэлт | 2018 оны 12-р сарын 31 | 2019 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)** | **761,858,852.9** | **858,269,273.0** |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 100,869,612.6 | 57,780,846.9 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 99,426,973.3 | 56,904,306.0 |
| 122 | Тусламжийн орлого | 1,442,639.3 | 876,540.8 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 660,989,240.3 | 800,488,426.1 |
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **652,378,453.3** | **772,007,627.3** |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 652,378,453.3 | 772,007,627.3 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 504,363,986.1 | 593,121,128.6 |

| | | | |
|---|---|---|---|
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 229,804,304.3 | 285,346,613.7 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 27,796,916.9 | 36,004,016.6 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 28,405,354.7 | 30,233,598.0 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 11,510,934.1 | 12,721,730.2 |
| 2105 | Нормативт зардал | 127,635,461.2 | 140,583,035.8 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 8,238,891.5 | 10,494,673.5 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 2,161,089.8 | 2,813,669.4 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 10,846,339.9 | 13,498,823.5 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 57,964,693.6 | 61,424,967.9 |
| 212 | ТАТААС | 0.0 | 3,677,786.8 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 148,014,467.2 | 175,208,711.8 |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)** | **109,480,399.6** | **86,261,645.7** |
| V | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V) | 93,583,294.2 | 83,883,180.9 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 93,583,294.2 | 83,883,180.9 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 93,583,294.2 | 83,883,180.9 |
| VI | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V) | -93,583,294.2 | -83,883,180.9 |
| VII | САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН | 358,030.8 | 45,623.1 |
| 14 | Бусад эх үүсвэр | 399,077.7 | 46,685.3 |
| 25 | САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ | 41,046.9 | 1,062.2 |
| VIII | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII) | 16,255,136.1 | 2,424,087.9 |
| 9 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 9,950,565.5 | 26,205,701.6 |
| 10 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 26,205,701.6 | 28,629,789.6 |

### 4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

| Код: | Тайлангийн үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **839,948,862.7** | **823,033,550.8** | **16,915,311.9** | **98.0** |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 735,710,907.4 | 726,808,099.2 | 8,902,808.2 | 98.8 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 581,790,561.6 | 574,006,837.1 | 7,783,724.5 | 98.7 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 282,637,871.9 | 281,085,091.4 | 1,552,780.5 | 99.5 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 35,822,026.4 | 35,659,780.0 | 162,246.4 | 99.5 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 30,623,120.0 | 29,801,211.9 | 821,908.1 | 97.3 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 11,145,960.1 | 11,004,309.4 | 141,650.7 | 98.7 |
| 2105 | Нормативт зардал | 138,133,124.7 | 136,996,614.2 | 1,136,510.5 | 99.2 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 16,227,282.8 | 15,977,657.9 | 249,624.9 | 98.5 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 1,029,551.2 | 972,250.5 | 57,300.7 | 94.4 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 10,830,285.9 | 10,654,984.1 | 175,301.8 | 98.4 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 55,341,338.6 | 51,854,937.8 | 3,486,400.8 | 93.7 |
| 212 | ТАТААС | 3,770,000.0 | 3,769,969.6 | 30.4 | 100.0 |
| 2121 | Төрийн өмчит байгууллагад олгох татаас | 3,770,000.0 | 3,769,969.6 | 30.4 | 100.0 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 150,150,345.8 | 149,031,292.4 | 1,119,053.4 | 99.3 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 2131 | Засгийн газрын урсгал шилжүүлэг | 129,951,940.3 | 129,002,716.2 | 949,224.1 | 99.3 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 20,198,405.5 | 20,028,576.3 | 169,829.2 | 99.2 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 104,237,955.3 | 96,225,451.7 | 8,012,503.6 | 92.3 |
| **III** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **839,948,862.7** | **823,031,924.9** | **16,916,937.8** | **98.0** |
| 31 | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 584,802,931.2 | 573,529,066.4 | 11,273,864.8 | 98.1 |
| 33 | НИЙГМИЙН ДААТГАЛААС САНХҮҮЖИХ | 228,170,400.8 | 221,061,351.2 | 7,109,049.6 | 96.9 |
| 35 | ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС | 26,975,530.7 | 28,441,507.2 | -1,465,976.5 | 105.4 |
| **4** | Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 0.0 | 60,761.3 | -60,761.3 | |
| **5** | Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 0.0 | 41,629.3 | -41,629.3 | |
| | Төсвийн гүйцэтгэлийн тохируулгын өөрчлөлт | | -17,506.1 | | |
| **6** | **ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ** | | | | |
| 61 | БАЙГУУЛЛАГЫН ТОО | 150 | 150 | 0 | |
| 62 | АЖИЛЛАГСАДЫН ТОО | 21,341 | 21,546 | -205 | |
| 65 | ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ | 21,341 | 21,546 | -205 | |

### 4.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

| Код: | Тайлангийн үзүүлэлт | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **27,624,899.50** |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 27,260,897.40 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 24,777,428.70 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 2,624,918.40 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 245,302.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 73,854.60 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 1,461,455.30 |
| 2105 | Нормативт зардал | 4,675,735.60 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 3,106,922.40 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 1,398,728.10 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 3,053,864.60 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 8,136,647.70 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 2,483,468.80 |
| 2131 | Засгийн газрын урсгал шилжүүлэг | 17,153.90 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 1,677,239.2 |
| 2133 | Олгосон санхүүжилт, шилжүүлэг | 789,075.60 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 364,002.10 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 364,002.10 |
| **I** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **27,532,219.30** |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 27,532,219.30 |
| III | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I) | -92,680.2 |
| 9 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 92,680.2 |
| 10 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 0.0 |

# ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
## АЛБАН ШААРДЛАГА

2020 оны 04 дугаар сарын 24 № 01/212 Улаанбаатар хот
САТ-2020/11/СТА-ТЕЗ

Хариуцлага тооцуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1-д заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасан цаглабарт хугацаанд Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Өмнөговь аймгийн Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн 2019 оны санхүүгийн тайланд бараа материалын үлдэгдэл зөрүүтэй, үнэ төлбөргүй хүлээн авсан бараа материалын орлого дутуу, цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал дутуу тайлагнасан, авлага хааж бүртгээгүй, өмнөх оны зөвлөмж хэрэгжүүлээгүй зэрэг нийт 2,944.4 сая төгрөгийн зөрчил илэрсэн тул Дүгнэлт өгөхөөс татгалзсан байна.

Энэ нь Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2-т "дараах тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ", 28.2.1-д "аудитад хамрагдсан байгууллагын санхүүгийн тайланд төрийн аудитын байгууллагаас санал, дүгнэлт өгөх боломжгүй тохиолдолд" гэсэн заалтын дагуу хариуцлага тооцуулах албан шаардлагыг хүргүүлж байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т "аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх...", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 тушаалаар батлагдсан "Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 4.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Холбогдох албан тушаалтанд хуульд заасны дагуу арга хэмжээ авах;
2. Албан шаардлагын биелэлтийг 2020 оны 06 дугаар сарын 15-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг төсвийн ерөнхий нягтлан бодогч Х.Отгонзулд хариуцуулав.

**АЛБАН ШААРДЛАГЫГ**

**ӨГСӨН:**
САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ
АХЛАХ АУДИТОР Ж.БОЛОРМАА

**ЗӨВШӨӨРСӨН:**
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД Д. САРАНГЭРЭЛ
ТӨСВИЙН ЕРӨНХИЙ НЯГТЛАН БОДОГЧ Х.ОТГОНЗУЛ

*Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.*

\\10.10.10.20\Bichig_Khereg\Alban Shaardlaga\2020\0423SAG8.Docx

001080756

Хавсралт 1

## 5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| дд | Харьяа байгууллагууд | Дүгнэлтийн хэлбэр | | | | Акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Зөрчилгүй | Хязгаарлалттай | Сөрөг | Дүгнэлт өгөхөөс татгалзсан | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 0 | Эрүүл мэндийн сайд | 1 | | | | - | - | 1 | - | 4 | 6,827,985.0 |
| 1 | Эрүүл мэндийн яам | 1 | | | | 1 | 2,346.4 | - | - | 3 | 105,077.4 |
| 2 | Эрүүл мэндийг дэмжих сан | 1 | | | | - | - | - | - | 4 | 32,259.2 |
| 3 | Эрүүл мэндийн хөгжлийн төв | 1 | | | | - | - | 1 | 12,590.9 | 5 | 43,471.3 |
| 4 | Улсын нэгдүгээр төв эмнэлэг | 1 | | | | - | - | 1 | 58,515.3 | 5 | 314,866.5 |
| 5 | Улсын хоёрдугаар төв эмнэлэг | 1 | | | | 1 | 2,525.7 | 1 | 123,900.0 | 2 | 3,072.3 |
| 6 | Улсын гуравдугаар төв эмнэлэг | 1 | | | | - | - | 1 | 58,582.1 | 3 | 271,270.6 |
| 7 | Уламжлалт анагаах ухаан, технологийн хүрээлэн | 1 | | | | - | - | - | - | 5 | 59,344.9 |
| 8 | Зоонозын өвчин судлалын үндэсний төв | 1 | | | | - | - | 1 | 13,085.2 | 1 | 10,000.0 |
| 9 | Хавдар судлалын үндэсний төв | 1 | | | | - | - | 1 | 153,241.8 | 3 | - |
| 10 | Цус сэлбэлт судлалын үндэсний төв | 1 | | | | - | - | 2 | 15,469.5 | 4 | 1,439.2 |
| 11 | Гэмтэл, согог судлалын үндэсний төв | 1 | | | | 1 | 3,000.0 | 1 | 31,547.8 | 1 | 89,422.3 |
| 12 | Арьсны өвчин судлалын үндэсний төв | 1 | | | | 1 | 5,405.5 | 2 | 23,620.9 | 5 | 12,279.2 |
| 13 | Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв | 1 | | | | 2 | 3,644.7 | 3 | 34,659.9 | 4 | 54,451.7 |
| 14 | Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв | 1 | | | | - | - | 3 | 246,800.0 | 2 | - |
| 15 | Эмгэг судлалын үндэсний төв | 1 | | | | 1 | 321.0 | 1 | - | 2 | - |
| 16 | Хүүхдийн төв сувилал | 1 | | | | - | - | 1 | - | 1 | - |
| 17 | Халдварт өвчин судлалын үндэсний төв | | 1 | | | 1 | 48,850.0 | 2 | 341,425.5 | 3 | 142,213.0 |
| 18 | Геронтологийн үндэсний төв | | 1 | | | 1 | 4,245.0 | 1 | 20,297.4 | 6 | 156,011.5 |
| 19 | Монгол Солонгосын дорнын анагаах ухааны төв | 1 | | | | - | - | - | - | 4 | 2,800.0 |
| 20 | Глобаль сангийн дэмжлэгтэй ДОХ-ын төсөл | 1 | | | | - | - | - | - | 2 | - |
| 21 | Глобаль сангийн дэмжлэгтэй сүрьегийн төсөл | 1 | | | | - | - | - | - | 2 | - |
| 22 | Архангай аймгийн эрүүл мэндийн байгууллагууд | 5 | | | | 1 | 1,952.0 | 2 | 13,468.0 | 3 | 47,509.0 |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 23 | Баян-Өлгий аймгийн эрүүл мэндийн байгууллагууд | 5 | 1 | | | 3 | 8,977.4 | 2 | 227,192.5 | 6 | 45,001.6 |
| 24 | Баянхонгор аймгийн эрүүл мэндийн байгууллагууд | 3 | 1 | | | 4 | 12,360.7 | 3 | 2,456.9 | 10 | 41,586.8 |
| 25 | Булган аймгийн эрүүл мэндийн байгууллагууд | 3 | | | | 2 | 383.0 | 3 | 11,335.6 | 8 | 35,629.3 |
| 26 | Говь-Алтай аймгийн эрүүл мэндийн байгууллагууд | 4 | 2 | 1 | | 7 | 16,684.4 | 8 | 658,320.3 | 2 | 89,987.4 |
| 27 | Говьсүмбэр аймгийн эрүүл мэндийн байгууллагууд | 2 | | | | 2 | 921.0 | 2 | 23,340.1 | 6 | 13,454.3 |
| 28 | Дархан-Уул аймгийн эрүүл мэндийн байгууллагууд | 2 | | | | 3 | 12,893.1 | - | - | 5 | 5,146.5 |
| 29 | Дорнод аймгийн эрүүл мэндийн байгууллагууд | 5 | | | | 3 | 11,545.2 | 5 | 257,179.5 | 6 | 32,852.0 |
| 30 | Дорноговь аймгийн эрүүл мэндийн байгууллагууд | 4 | 1 | | | 2 | 676.4 | 5 | 607,096.7 | 8 | 247,758.4 |
| 31 | Дундговь аймгийн эрүүл мэндийн байгууллагууд | 4 | | | | - | - | 5 | 29,224.0 | 0 | - |
| 32 | Завхан аймгийн эрүүл мэндийн байгууллагууд | 6 | 1 | | | - | - | 1 | 18,683.1 | 2 | 4,335.7 |
| 33 | Орхон аймгийн эрүүл мэндийн байгууллагууд | 1 | | | | 2 | 2,880.0 | 2 | 49,196.6 | 5 | 5,320.0 |
| 34 | Өвөрхангай аймгийн эрүүл мэндийн байгууллагууд | 5 | | | | 1 | 109.8 | 3 | 27,661.8 | 5 | 217,734.5 |
| 35 | Өмнөговь аймгийн эрүүл мэндийн байгууллагууд | 5 | | | 1 | 1 | 559.0 | - | - | 9 | 275,100.0 |
| 36 | Сэлэнгэ аймгийн эрүүл мэндийн байгууллагууд | 5 | | | | 5 | 11,333.4 | 4 | 33,641.0 | 7 | 140,394.5 |
| 37 | Сүхбаатар аймгийн эрүүл мэндийн байгууллагууд | 2 | 1 | | | 4 | 9,781.9 | 13 | 138,813.4 | 3 | 36,677.0 |
| 38 | Төв аймгийн эрүүл мэндийн байгууллагууд | 2 | | | | 2 | 1,960.0 | 2 | 5,504.7 | 6 | 72,356.5 |
| 39 | Увс аймгийн эрүүл мэндийн байгууллагууд | 6 | | | | 4 | 2,270.3 | - | - | 3 | 4,660.6 |
| 40 | Ховд аймгийн эрүүл мэндийн байгууллагууд | 4 | 1 | | | 3 | 25,570.2 | 1 | 78,803.5 | 13 | 370,229.5 |
| 41 | Хөвсгөл аймгийн эрүүл мэндийн байгууллагууд | 7 | | | | 3 | 1,854.5 | 1 | 496.2 | 12 | 5,885.6 |
| 42 | Хэнтий аймгийн эрүүл мэндийн байгууллагууд | 6 | | | | 2 | 1,698.1 | 7 | 71,938.5 | 6 | 11,780.8 |
| 43 | Нийслэл, дүүргүүдийн эрүүл мэндийн байгууллагууд | 21 | 1 | | | 5 | 2,757.8 | 13 | 225,105.3 | 78 | 331,112.6 |
| | **ДҮН** | **127** | **11** | **1** | **1** | **68** | **197,506.5** | **105** | **3,613,194.1** | **274** | **10,160,476.7** |
| | **НИЙТ ДҮН** | | | | | | | | | **447** | **13,971,177.3** |